

2016 онд Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон төсөл, хөтөлбөрийн тендерийн гүйцэтгэлийг ил тод мэдээлэх

Тухайн жилд батлагдсан төсөв, төсвийн зарцуулалт гүйцэтгэл, нэмэлтээр ирж буй санхүүжилт, хагас бүтэн жилийн санхүүгийн тайланг Шилэн дансны тухай хууль болон Төсвийн тухай хууль бусад хууль тогтоомжийн хүрээнд гаргаж хуулийн хугацаанд тайлагнан удирдлагыг үнэн зөв мэдээллээр ханган ажилласан. 2016 онд гаргасан санхүүгийн тайлан мэдээг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан ил тод тавьж мэдээллэн ажиллаж байна. Төсвийн мэдээллийг <http://info.shilendans.gov.mn/login> хаягаар нэвтрэн мэдээллийг оруулан <http://shilendans.gov.mn/org/1374> цахим хуудсаар тогтмол мэдээлж ажиллаа.

- Шилэн дансны тухай хууль хэрэгжсэнтэй холбойгоор сар бүр цалигийн зардлаас бусад 5 саяаас дээш орлого, зарлагын гүйлгээ, жилийн төсөв, сарын гүйцэтгэлийн хамт хуулийн хугацаанд бүх мэдээллийг байгууллагын цахим сайт болон мэдээллийн самбарт байршуулан ил тод нээлттэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Швейцарийн хамтын ажиллагаа, германы олон улсын хамтын ажиллагааны эрчим хүчний үр ашиг төсөлөөс 348,0 сая төгрөг, ЭМСЯ-наас 380,0 сая төгрөг, Ховд аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаас 220,0 сая төгрөг, санхүүжилтийг шийдвэрлүүлж 948,0 сая төгрөгийн саанхүүжилтийг шийдвэрлэж нээлттэй тендер зарлагдаж “Ховдын өргөө” ХХК шалагарч халдвартын барилгын их засварын ажлыг 2016 он 06-р сарын 20 нд эхлүүлж 09-р сарын 25 –нд дуусгаж улсын комисст хүлээлгэн өгч тус барилгад эмчилгээ үйлчилгээ хэвийн явагдаж байна. Эмчилгээний хоолны тасгийн хоолны бэлтгэл ажлыг хангах тоног төхөөрөмжүүдийг koika олон улсын байгууллагын дэмжлэг тусламжтайгаар нийт 28,0 сая төгрөгийн санхүүжилтээр шинэчилсэн. Мөн 2016 онд Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд 470,6 сая төгрөгний 125 компьютер дагалдах тоног төхөөрөмж, Цусны салбар станцад Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагаас 6,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Азийн хөгжлийн банкны ЭМХХ- 5 хүрээнд 720,0 сая төгрөгний тоног төхөөрөмж нийлүүлсэн ба цусны салбар станцын байрыг ажилчдын ая тухтай орчинг бүрдүүлэх эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр иж бүрэн засвар хийсэн зэрэг томоохон бүтээн байгуулалттай холбоотой мэдээ тайланг цаг тухай бүр нь гаргаж мэдээллийн самбар, цахим хуудсанд ил тод байршуулсан.

- БОЭТ нь 2014 оноос хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээний хоолны чанар хүртээмжийг дээшлүүлэх, стандарт шаардлага хангасан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх нээлттэй тендер зарлаж Мах, хүнсний ногоо, сүү сүүн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Мах бэлтгэн нийлүүлж байгаа “ХОВД ДӨРГӨН ХХК”, Сүү, сүүн бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа “ҮҮДЭНГИЙН ЦАГААН ТОЛГОЙ” Хүнсний ногоог Хувиараа аж эрхэлдэг А. Гансүх нартай гэрээ байгуулан гэрээний заалтын дагуу ариун цэвэр, халдвар хамгаалалын шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэн хамтран ажиллаж байна. Гэрээг хагас бүтэн жилээр дүгнэж гэрээний заалтын дагуу зах зээлийн үнэ ханшаас доогуур, стандарт шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэхэд нь хяналт тавин ажиллаж байна. Улсын төсөвөөс 2016 онд эмчилгээний хоолны нийт төсөв 187,5 сая төгрөгийн батлагдсан зардалд багтаан үйл ажиллагаагаа явуулсан. Гэрээний дүн бусад мэдээллийн талаар шилнэ данс болон байгууллагын вэб сайтад байршуулан ил тод байдлыг хангаж ажиллаа. www.khovdboet.mohs.mn/

2016 онд БОЭТ-ийн эмийн төсөв 1,122,000,000 төгрөгөөр батлагдсан. Эм, эмнэлэгийн хэрэгсэл,урвалж бодис, оношлуурын нээлттэй тендерийн шалгаруулалтыг нийт эмийн төсвийн 80%-д буюу 972,300,000 төгрөгөнд зарлан 36 багцаар худалдан авах ажиллагааны тендерийн хуулийн дагуу БОЭТ-ийн захирлын тушаалаар үнэлгээний хороог байгуулан www.e-procurement.mn цахим хуудсанд нээлттэй тендер зарлаж урилга байршуулан нийтэд мэдээлж явуулсан. Тенднерт нийт 21 компани оролцож үнийн санал, материалаа ирүүлснээс үнэлгээний хорооны гишүүд үнэлгээ хийж 14 компани шалгарч 2016 оны 02 дугаар сарын 05- нд гэрээ байгуулан эм, эмнэлэгийн хэрэгсэл, урвалж оношлуурыг хуваарийн дагуу нийлүүлж эхэлсэн. Улирал бүр эм, эмнэлэгийн хэрэгсэл, урвалж оношлуурын нийлүүлэлт болон тендерийн гүйцэтгэлийг БОЭТ-ий санхүүгийн шилэн данс болон захирлын дэргэдэх зөвлөлд тайлагнан ажиллаж байна

Дээр ажил үйлчилгээнүүдийг зохион байгуулснаар Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон төсөл, хөтөлбөрийн тендерийн гүйцэтгэлийг

ил тод мэдээллэх, шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах заалтыг бүрэн хэрэгжүүлэн байгууллагын удирдлагыг үнэн зөв мэдээллээр шуурхай хангаж, оновчтой зөв шийдвэр гарган төсөл хөтөлбөрийн байгууллагад хамтран ажиллах санал, төсөл боловсруулан хүргүүлснээр байгууллагын үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжүүдийг 1,1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн, үйлчлүүлэгчдийн ая тухтай орчин бүрдүүлсэн, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргүй ажилласан зэрэг ололт амжилтууд гарсан. Энэ нь байгууллагын удирдлагын манлайлал, дунд шатны менежерүүд, ажилчдын хамтын ажиллагааны үр дүн юм.

2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТООЛЛОГЫН НЭГДСЭН ДҮН

Тооллогоор 41 тасаг кабинетуудад нийт 96 нэр төрлийн 565 ширхэг 4,929,978,6 мянган төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж болон багаж хэрэгсэлүүдийг тоолж бүртгэгдлээ.

№	Ангилал	2016 оны эхний үлдэгдэл /мян, төг/	Шинээр нэмэгдсэн /мян, төг/	2016 оны эцсийн үлдэгдэл /мян,төг/
1	Барилга байгууламж	5,349,661,5	-	5,349,661,5
2	Тээврийн хэрэгсэл	354,524,3	-	354,524,3
3	Тоног төхөөрөмж	4,426,399,3	669,824,8	5,096,224,2
4	Тавилга эд хогшил	122,025,1	13,275,0	135,300,1
5	Програм хангамж	28,695,0	-	28,695,0
6	Бусад хөрөнгө	113,518,8	470,128,8	583,647,6
	Нийт хөрөнгө	10,394,824,2	1,153,228,6	11,548,052,9

2016 онд нийт 41 нэр төрлийн 74 ширхэг 669,824,8 /цусны салбар станц/ төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж , 6 нэр төрлийн 67 ширхэг 13,275,0 төгрөгийн үнэ бүхий тавилга аж ахуйн эд хогшил, 24 нэр төрлийн 290 ширхэг 470,128,8 төгрөгийн үнэ бүхий бусад үндсэн хөрөнгө /Цахим төслийн компьютерууд/ тус тус 1,153,228,6 төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж нийт хөрөнгө 11,548,052,9 төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэгдсэн.

